



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
БАЙДАЛ**

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2018/6



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл	
Аргачлалын тайлбар.....	
I. Нийгмийн байдал.....	
II. Нийгмийн даатгал, халамж.....	
III. Эрүүл мэнд	
IV. Гэмт хэрэг	
V. Үнэ.....	
VI. Төсөв.....	
VII. Хөдөө аж ахуй	
VIII. Аж үйлдвэр	
IX. Цаг уур.....	
Хавсралт.....	



Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо

+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй

* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

• Хөдөлмөр:

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

• Нийгмийн даатгал, халамж:

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт



мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

- ✓ 1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- ✓ 1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

- ✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргийг нэгтгэн оруулсан.

- ✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

- ✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.

- ✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

- ✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны эхний 2 сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.



- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын Тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул, хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал



I. Нийгмийн байдал


I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 437, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 260 байгаагийн 141 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 38 буюу 12.8 хувиар, өмнөх сараас 28 буюу 9.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зургаадугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 84 ажлын байрны захиалга иржээ.

Тайлант сард 36 иргэн ажилд зуучлагдсаны 15 буюу 41.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст



Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 57, 25-34 насны 91, 35-44 насны 67, 45-54 насны 37, 55 түүнээс дээш насны 8 иргэн байна.

I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 6 сарын байдлаар 238 эх амаржиж, 239 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 77 буюу 47.8 хувиар, төрсөн хүүхдийн тоо 74 буюу 44.8 хувиар тус тус өссөн байна.

Нас баралт 36, бүртгүүлсэн гэр бүл 50, цуцалсан гэр бүл 13 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 1 буюу 7.1 хувиар, нас баралт 16 буюу 30.8 хувиар тус тус буурч, бүртгүүлсэн гэр бүл 17 буюу 51.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 4 хүүхэд үрчлэгдсэн.



Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 269 хүн шилжин ирж, 248 хүн шилжин явсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал шилжин ирэлт 17.0 хувиар, шилжин явалт 15.3 хувиар тус тус өсчээ.

Зураг 1.2.Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2018 оны эхний 6 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 5131.1 сая төгрөг, зарлага 5250.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс орлого 943.3 сая төгрөгөөр буюу 22.5 хувиар, зарлага 1228.0 сая төгрөгөөр буюу 30.5 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 133.6 хувьтай, зарлагын гүйцэтгэл 99.1 хувьтай байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаний салбарууд 2018 оны эхний хагас жилд 190.2 сая төгрөгийн орлого олж, 24.0 сая төгрөгийн нөхөн төлбөр хийсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 41.3 хувиар, 25.7 хувиар нэмэгдсэн байна. Нөхөн төлбөрийн 64.7 хувийг жолоочийн хариуцлагын даатгалд тус зориулсан байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2018 оны эхний 6 сарын байдлаар 5458 хүнд 1033.0 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 1890 хүн буюу 53.0 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 269.5 сая төгрөг буюу 35.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2018 оны эхний 6 сарын байдлаар 1835 хүн хамруулж 578.8 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 913 хүн буюу 99.0 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 209.4 сая төгрөг буюу 56.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2018 оны эхний 6 сарын байдлаар 3623 хүн хамруулж 454.3 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 977 хүн буюу 36.9 хувиар, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 60.2 сая төгрөг буюу 15.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



II.3 Дундаж цалин

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 6 дугаар сарын мэдээгээр 201 байгууллагын 5076 даатгуулагч иргэн, үүнээс 536 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 399 ажилтны дундаж цалин 690.4 мянган төгрөг, төсөвт 53 байгууллагын 1622 ажилтны дундаж цалин 671.1 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 620 ажилтны дундаж цалин 1119.2 мянган төгрөг, 118 ХХКомпаний 1759 ажилтны дундаж цалин 819.8 мянган төгрөг, бусад 17 аж ахуйн нэгж байгууллагын 140 ажилтны дундаж цалин 408.4 мянган төгрөг боллоо.

Зураг II.1. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2018 оны эхний 6 сарын байдлаар




III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2018 оны эхний 6 сарын байдлаар 244 эх амаржиж, 2017 оны мөн үетэй харьцуулахад 45 буюу 22.6 хувиар өссөн байна. Амьд төрсөн хүүхэд 244 үүнээс 120 нь хүү, 124 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 45 буюу 22.6 хувиар өссөн байна.

Он гарсаар 0-1 хүртэлх, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл болон эхийн эндэгдэл бүртгэгдээгүй болно.


Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 6 сарын байдлаар





Халдварт өвчин эхний 6 сарын байдлаар 139 буюу 10000 хүн амд 79.9 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 34 тохиолдлоор өсчээ.

Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 6 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 55744 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 971 буюу 1.7 хувиар буурч, 2603 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 75 буюу 3.0 хувиар өссөн байна.

2018 оны эхний 6 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 3299, халдварт өвчин 139 бүртгэгдсэн байна.

Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхасын эндэгдэл, жил бүрийн эхний 6 сарын байдлаар






IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2018 оны эхний 6 сарын байдлаар 112 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 22 буюу 24.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 6 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо өсөхөд хүний амьд явах эрхийн эсрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 38.1 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 65 байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.2 дахин өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 40.0 болсон нь өмнөх оны мөн үеэс 25 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 56 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 15.2 хувиар буурсан байна.

Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 6 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2018 оны эхний 6 сарын байдлаар 415.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 190.0 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 218.0 сая төгрөгөөр буюу 2 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 41.0 сая төгрөг буюу 27.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2018 оны эхний 6 сарын байдлаар давхардсан тоогоор 369 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 13 хүнээр буюу 3.7 хувиар буурсан байна.



Зураг IV.3. Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 6 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2018 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 5.4 хувиар, 2017 оны жилийн эцсээс 3.7 хувиар, өмнөх сараас 0.6 хувиар өссөн байна.

Хүснэгт V.1. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 6 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	2018.VI	2018.VI	2018.VI
	2017.VI	2017.XII	2018.V
Ерөнхий индекс	105.4	103.7	100.6
Хүнсний бараа, ундаа, ус	103.0	108.2	100.4
Согтууруулах ундаа, тамхи	108.9	104.2	100.0
Хувцас, бөс бараа, гутал	101.3	100.0	99.9
Орон сууц, ус, цахилгаан, түлш	120.0	100.6	100.8
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	108.2	103.8	103.6
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	102.4	101.1	101.9
Тээвэр	105.8	104.3	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.9	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.3	100.0	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	104.5	105.1	100.0
Бусад бараа, үйлчилгээ	103.2	100.3	100.3

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ


**VI. Төсөв санхүү, банк**

2018 оны эхний 6 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 7057.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 7440.3 сая төгрөг болж 105.4 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 8715.3 сая төгрөг, гүйцэтгэлээр 7334.8 сая төгрөг болж 84.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018 оны эхний 6 сарын байдлаар авлагын үлдэгдэл 43.5 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 150.7 сая төгрөг байна.

Зураг VI.1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр




Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбарын эхний хагас жилийн зарим үзүүлэлтийг танилцуулбал цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид давхардсан тоогоор 18.5 мянгад хүрч, зээлийн бүтээгдэхүүн дунджаар 47 болсон байна. Давхардсан тоогоор 39 аж ахуйн нэгж байгууллагад 2.5 тэрбум төгрөгийн, 8319 иргэнд 55.4 тэрбум төгрөгийн, үүнээс 434 малчинд 2.4 тэрбум төгрөгийн зээл олгосон үзүүлэлттэй байна.

**VII. Мал аж ахуй, газар тариалан**


Аймгийн хэмжээнд 2018 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 201476 хээлтэгч малын 141521 буюу 70.2 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 84.9 хувьтай байна. 2018 оны эхний 6 сарын байдлаар 30591 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 14.1 дахин нэмэгдсэн байна. Том малын зүй бус хорогдлын 20.8 хувь нь хээлтэгч мал байна.

Зураг VII.1. Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, толгойгоор






Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, толгойгоор



2018 оны 6 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 40.2 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 1.9 га талбайгаар буюу 11.3 хувиар, хүнсний ногоо 4.3 га талбайгаар буюу 24.7 хувиар буурч тэжээлийн ургамал 7.7 га талбайгаар буюу 2.8 дахин нэмэгдсэн байна.

Зураг VII.3.Тариалсан талбай, жил бүрийн 6 дугаар сарын байдлаар, га



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2018 оны эхний 6 сарын байдлаар 24.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.1 тэрбум төгрөг буюу 9.6 хувиар, оны үнээр 24.5 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1.3 тэрбум төгрөг буюу 5.5 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 94.5 хувь буюу 22.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 94.6 хувь буюу 23.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.



Зураг VIII.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр



■ Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж ■ Боловсруулах аж үйлдвэр ■ Уул, уурхай олборлох аж үйлдвэр



IX. Цаг агаарын мэдээ 6 дугаар сарын байдлаар

Хур тунадас: Энэ сард нийт 5.7 мм хур тунадас орсон байна.



Салхи: Хамгийн их хурд нь 18 м/сек хүрч салхилсан.

Агаарын температур: Дунджаар 19.6 хэм дулаан, хамгийн ихдээ 33.0 хэм дулаан байлаа.

2018 оны 7 дугаар сарын ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Уур амьсгалын дунджаар агаарын температурын сарын дундаж 22-27 хэм дулаан байх бөгөөд олон жилийн дунджаас 1.0-2.0 хэмээр дулаан байх төлөвтэй. Хоёрдугаар арав хоногийн сүүлчээр бага зэрэг сэрүүсч, шөнөдөө 14-19 хэм, өдөртөө 24-29 хэм дулаан байна.

Говьсүмбэр аймгийн нутгаар уур амьсгалын дунджаас бага бороо орох төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхэн ба дунд үе, хоёрдугаар арав хоногийн дунд үе, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлчээр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар түр зуурын бороо орох төлөвтэй. Дуу цахилгаантай. Салхи борооны өмнө зарим газраар түр зуур ширүүснэ.





ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд	хүүхэд	199	244	122.6
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	298	260	87.2
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	105	139	132.4
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	90	112	124.4
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	7585.0	7440.3	98.1
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	7095.1	7334.8	103.4
Авлага	сая.төг	15.6	43.5	278.8
Өглөг	сая.төг	99.3	150.7	151.8
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	21918.2	24025.5	109.6
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	23207.3	24477.3	105.5
Төллөсөн хээлтэгч	толгой	140828	141521	100.5
Гарсан төл	толгой	141641	142481	100.6
Хорогдсон төл	толгой	1370	21560	1573.7
Бойжсон төл	толгой	140271	120921	86.2
Том малын зүй бусын хорогдол	толгой	2165	30591	1412.9



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 6 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	457	437	95.6
Үүнээс: эмэгтэй	264	249	94.3
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	298	260	87.2
Үүнээс: эмэгтэй	165	141	85.5
Ажлын байрны захиалга	31	84	270.6
Ажилд зуучлагдсан иргэд	17	22	129.4
Үүнээс: эмэгтэй	11	16	145.5

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Амаржсан эх	161	238	147.8
Төрсөн хүүхэд	165	239	144.8
Үрчлэгдсэн хүүхэд	2	4	200.0
Бүртгүүлсэн гэр бүл	33	50	151.5
Цуцалсан гэр бүл	14	13	92.9
Нас баралт	52	36	69.2
Шилжин ирсэн	230	269	117.0
Шилжин явсан	215	248	115.3

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сангийн төрөл	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
НД-ын сангийн орлого, сая.төг	4187.8	5131.1	122.5
НД-ын сангийн зарлага, сая.төг	4022.2	5250.2	130.5

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ



II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VI		2018 I-VI		$\frac{2018 \text{ I} - \text{VI}}{2017 \text{ I} - \text{VI}} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	3568	763.5	5458	1 033.0	153.0	135.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	922	369.4	1835	578.8	199.0	156.7
Халамжийн тэтгэвэр	260	194.2	250	201.1	96.2	103.6
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	662	175.2	1585	377.7	239.4	215.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	2646	394.1	3623	454.3	136.9	115.3
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж, насны хишиг	712	129.2	1312	144.8	184.3	112.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	91	15.5	71	14.1	78.0	90.7
Нийгмийн халамжийн үйлчилгээ	379	17.4	694	47.7	183.1	274.1
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	250	64.4	294	84.9	117.6	131.8
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	5	5.1	5	5.1	100.0	100.0
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1209	162.6	1247	166.4	103.1	102.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ



III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Төрсөн эх	199	244	122.6
Амьд төрсөн хүүхэд	199	244	122.6
Эрэгтэй	105	120	114.3
Эмэгтэй	94	124	131.9
Амьгүй төрсөн хүүхэд	1	0	-
Нийт нас баралт	42	27	64.3
Эмнэлгийн нас баралт	4	5	125.0
Хоног болоогүй нас баралт	4	1	25.0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	0	-
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	3	0	-
Эмчлэгдсэн өвчтөн	2 528	2 603	103.0
Амбулаторийн үзлэг	56 715	55 744	98.3
Халдварт өвчин	105	139	132.4

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ , жил бүрийн эхний 6 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	90	112	124.4
Хүний амьд явах эрхийн эсрэг, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	42	58	138.1
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	30	34	113.3
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	3	100.0
Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	10	6	60.0
Хүүхдийн эсрэг гэмт хэрэг	0	9	-



Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	4	0	-
Бусад гэмт хэрэг	1	2	200.0
Гэмт хэрэгт холбогдогсад	110	56	50.9
15 хүртэлх насны	2	0	-
16-34 насны	67	35	52.2
35 ба түүнээс дээш насны	41	21	51.2
Боловсрол – Дээд	19	11	57.9
Боловсрол - Тусгай дунд	6	7	116.7
Боловсрол – Бүрэн дунд	34	21	61.8
Боловсрол – Бүрэн бус дунд	28	11	39.3
Боловсрол – Бага	6	5	83.3
Боловсролгүй	17	2	11.8
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн	9	14	155.6
Ажилгүй иргэд үйлдсэн	48	31	64.6
Эмэгтэй хүн оролцсон	15	13	86.7
Хүүхэд оролцсон	9	4	44.4
Бүлгээр үйлдсэн	7	6	85.7
Согтуугаар үйлдсэн	34	32	94.1
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	90	112	124.4
Гудамж талбай, олон нийтийн газар	24	30	125.0
<u>Гэмт хэргийн улмаас нас барсан</u>	3	2	66.7
<u>Гэмт хэргийн улмаас гэмтсэн</u>	66	56	84.8
Учирсан хохирол / сая.төг /	197.0	415.0	210.7
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	149.0	190.0	127.5

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Нийт орлого	7 585.0	7 440.3	98.1
Урсгал орлого	3 009.9	2 480.2	82.4
Татварын орлого	2 237.5	2 237.6	100.0
Татварын бус орлого	772.4	242.6	31.4
Тусламжийн орлого	4 575.1	4 960.1	108.4

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ



VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Нийт зарлага	7 095.1	7 334.8	103.4
Урсгал зардал	6 938.8	6 648.6	95.8
Хөрөнгийн зардал	126.3	486.2	385.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Авлага	15.6	43.5	278.8
Өглөг	99.3	150.7	151.8
Төсөвт байгууллагын тоо	49	49	100.0
Төсөвт байгууллагын ажиллагсад	783	783	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Төрөл	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Бүгд	140 828	141 521	100.5
Ингэ	120	139	115.8
Гүү	3 974	2 715	68.3
Үнээ	3 666	3 309	90.3
Эм хонь	69 113	71 775	103.9
Эм ямаа	63 955	63 583	99.4

VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сумд	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Дүн	140 828	141 521	100.5
<u>Баянтал</u>	21 590	26 248	12.6
Сүмбэр	102 074	98 483	96.5
<u>Шивээговь</u>	17 164	16 790	97.8



VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Төрөл	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Бүгд	140 271	120 921	86.2
Ботго	116	133	114.7
Унага	3 957	2 513	63.5
Тугал	3 638	3 100	85.2
Хурга	68 838	63 702	92.5
Ишиг	63 722	51 473	80.8

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сумд	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Дүн	140 271	120 921	86.2
<u>Баянтал</u>	21 720	25 036	115.3
Сүмбэр	101 333	78 720	77.7
<u>Шивээговь</u>	17 218	16 790	97.5

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Төрөл	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Бүгд	2 165	30 591	1 412.9
Тэмээ	3	7	233.3
Адуу	29	1 147	3 955.2
Үхэр	105	1 607	1 530.5
Хонь	803	11 269	1 403.4
Ямаа	1 225	16 561	1 351.9

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сумд	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Дүн	2 165	30 591	1 412.9
<u>Баянтал</u>	255	2 217	869.4
Сүмбэр	1 827	27 897	1 526.9
<u>Шивээговь</u>	83	477	574.7



VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Төрөл	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Бүгд	429	6 357	1 481.8
Тэмээ	0	1	-
Адуу	7	288	4 114.3
Үхэр	27	332	1 229.6
Хонь	208	2 126	1 022.1
Ямаа	187	3 610	1 930.5

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Сумд	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Дүн	429	6 357	1 481.8
<u>Баянтал</u>	31	354	1 141.9
<u>Сүмбэр</u>	377	5 878	1 559.2
<u>Шивээговь</u>	21	125	595.2

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Нийт	21 918.2	24 025.5	109.6
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	19 830.4	22 694.7	114.4
Боловсруулах аж үйлдвэр	869.7	60.8	7.0
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	1 218.1	1 270.0	104.3

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 6 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 I - VI}{2017 I - VI} \%$
Нийт	23 207.3	24 477.3	105.5
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	21 252.2	23 155.0	109.0
Боловсруулах аж үйлдвэр	766.2	51.5	6.7
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	1 188.9	1 270.8	106.89



VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 6 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I-VI	2018 I-VI	$\frac{2018 \text{ I} - \text{VI}}{2017 \text{ I} - \text{VI}}\%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	21 252.2	23 155.0	109.0
Нүүрс гаргалт /үнийн дүнгээр, сая.төг/	19 830.4	22 694.7	114.4
Ажиллагсад	553	537	97.1

Е-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017